

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР



СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАА



Улаанбаатар хот
2025 он

Баянгол дүүргийн нийгмийн даатгалын газраас үйлчилгээ авахаар ирсэн иргэд даатгуулагчдын сэтгэл ханамжийн судалгаа

Нийгмийн даатгалын байгууллагын албан хаагчид бид төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, чирэгдэлгүй хүргэж үйлчлүүлэгчийн байр сууринаас тэдэнтэй харилцаж сайхан сэтгэгдэл үлдээж “Даатгуулагчийнхаа итгэл найдвар, сэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэх” эрхэм зорилгодоо хүрэхэд бүхий л үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллах ёстой. Энэ үүргийнхээ хүрээнд албан хаагчдадаа өдөр тутам ажлын байранд ажиллахдаа ёс зүйтэй, харилцаа хандлагадаа анхаарах, иргэдийн тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэж ажиллах талаар шаардлагатай зөвлөмж чиглэлүүдийг өгч ажиллаж байна.


Нийгмийн даатгалын үйлчилгээ авахаар ирсэн иргэд даатгуулагч, ажил олгогч байгууллагуудад холбогдох мэдээ мэдээллийг хууль тогтоомжид зааснаар түргэн шуурхай хүргэх, чиглүүлэх, зөвлөгөө өгөх, хяналт тавих чиг үүрэг бүхий “ХӨТӨЧ БАЙЦААГЧ”-г 2025 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн томилон ажиллуулж байна.

Ингэснээр тус газраас үйлчилгээ авахаар ирсэн иргэд даатгуулагчид аль цонхноос ямар үйлчилгээ авахаас эхлээд шаардлагатай баримт бичгийн жагсаалт, өргөдөл, санал хүсэлт гээд олон асуудлыг нэг доор шийдвэрлүүлэх боломжтой юм. Мөн сэтгэл ханамжтай үйлчлүүлсэн иргэдээс талархал бичиж үлдээх болсон нь хэрэгжүүлж байгаа ажлын үр дүн юм.


Газрын даргын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын дагуу нийгмийн даатгалын үйлчилгээ авахаар ирсэн иргэд даатгуулагчдаас сэтгэл ханамжийн судалгаа авах ажлыг зохион байгууллаа.

Судалгааны үр дүнг харуулбал:

1. Таны нас?




2. Таны хүйс?




3. Та ямар чиглэлийн үйлчилгээ авахаар ирсэн бэ?




4. Та нийгмийн даатгалын шинээр нэвтрүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийг ихэвчлэн ямар эх сурвалжаас авдаг вэ?




5. Та нийгмийн даатгалын үйлчилгээний талаарх мэдээллийг хангалттай авч чаддаг уу?




6. Та нийгмийн даатгалын байцаагч, ажилтануудын харилцаа хандлагад үнэлгээ өгнө үү?




7. Та нийгмийн даатгалын цахим үйлчилгээг ашигладаг уу?



8. Нийгмийн даатгалын үйлчилгээг цахимаар авахад танд ямар хүндрэл тулгардаг вэ?



9. Та өнөөдрийн авахаар ирсэн үйлчилгээгээ бүрэн гүйцэд авч чадсан уу?



Сэтгэл ханамжийн судалгааг 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 01-ний өдрийн хооронд нэг сарын хугацаанд үйлчилгээ авахаар ирсэн иргэд даатгуулагчдаас цаасан анкет хэлбэрээр авсан. Судалгаанд нийт 600 гаруй иргэд даатгуулагчид хамрагдсан байна. Судалгааны үр дүнгээс харахад 46-54 насны иргэд дийлэнх хувийг эзэлж байгаа нь өндөр насны тэтгэвэрт гарах нас ойртсон тул зөвлөгөө мэдээлэл авах шаардлага үүссэнийг харуулж байна. Мөн Ажилгүйдлийн тэтгэмж авах талаар болон ААНБ-ын шимтгэл төлөлттэй холбоотой асуудлаар үйлчилгээ авахаар ирсэн иргэд өндөр хувийг эзэлж байна. Нийгмийн даатгалын үйлчилгээг цахимаар авахад хүндрэлтэй байдаг талаар судалгаанд оролцогчдын ихэнх хувь нь хариулсан байна. Цаашид цахим үйлчилгээ хөгжүүлэлтийн ажлыг сайжруулах, түгээн дэлгэрүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатайг судалгааны үр дүн харуулж байна.

Тус газраас улиралд нэг удаа үйлчилгээ авахаар ирсэн иргэд даатгуулагчдаас сэтгэл ханамжийн судалгааг авч үр дүнг нийт ажилтан албан хаагчид болон хариуцсан хэлтсийн удирдлагуудад танилцуулан шинэ шинэлэг ажлуудыг зохион байгуулж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулан ажиллах болно.

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР